



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/55

Хөхбүрд

Мэргэн 4 дүгээр багийн нутаг “Ар гуугын худаг”
нэртэй газарт үхрийн боом өвчин Баянхонгор
аймгийн лабораторын шинжилгээгээр батлагдсан
тул хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4, 15.5, 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.3, 19 дүгээр зүйл, 20 дугаар зүйл, Гамшгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторийн 25-223 дугаар шинжилгээний хуудсыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Мэргэн 4 дүгээр багийн нутаг “Ар гуугын худаг” гэдэг газар үхрийн боом өвчин батлагдсантай холбогдуулж 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Малын халдварт боом өвчний хорио цээрийн дэглэмийн үед мэргэжил арга зүйгээр хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Малын халдварт боом өвчний хорио цээрийн дэглэмийн үед постонд ажиллах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд “Ар гуугын худаг”-ын ойр орчмын нутаг дэвсгэрт 5 км-ын радиуст хүн малын ариутгал хийж, хөдөлгөөнт эргүүл, хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд Худгийн өвөр, Бөмбөг, толгой, Талын толгой орчмын нутаг дэвсгэрийн бүсээс гарах мал, амьтны, тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглож ажиллахыг ажлын хэсэгт хариуцуулсугай.

4.Хил залгаа багуудын нутаг дэвсгэрт 10 км-ын радиуст хаваржиж буй өрхийн бүх малыг вакцинд хамруулж, сэжигтэй шинж тэмдэг илэрвэл сумын

Онцгой байдлын штабт цаг алдалгүй түргэн шуурхай мэдээлж ажиллахыг “Асгамба” мал эмнэлгийн эрхлэгч (Л.Сэргэлэн), Амгалан ариун сүрэг ХХК-ны малын их эмч (Т.Энх-Амгалан), Хишиг тайжын овоо ХХК-ны малын эмч (Б.Лхагвасүрэн) нар хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тайлан мэдээг тухай бүр гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ё.Дамдинпүрэв)-д үүрэг болгосугай.

5.Мал, амьтны халдварт боом өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 01-ний дотор шуурхай зохион байгуулж, дүн мэдээг 7 хоног тутам аймгийн мал эмнэлэгийн газарт мэдээлж мал, амьтны халдварт боом өвчний талаар ард иргэдэд ухуулга, сургалт сурталчилгаа хийж ажиллахыг мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч (Ж.Ёндонпил), Эрүүл мэндийн төвийн дарга (С.Отгонжаргал) нарт даалгасугай.

6.Онцгой байдал зарласан хугацаанд техник, хэрэгсэл, хоол хүнсний зардалд Засаг даргын нөөцөөс 16,028,000 (Арван зургаан сая хорин найман мянган) төгрөгөөр санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Д.Отгонцэцэг), Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт зөвшөөрсүгэй.


7.Голомт бүсэд ажиллах иргэдийн хүнсний хэрэгцээг хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал түр орлон гүйцэтгэгч (Э.Сугар), Эрүүл мэнд төвийн дарга (С.Отгонжаргал), Цэцэрлэгийн эрхлэгч (Э.Тулгаа), Соёлын төвийн дарга (Д.Баянбилэг) нарт хариуцуулсугай.

8.Дээрх ажлын хэсгийн аюулгүй байдлыг хангаж хэв журам сахиулж ажиллахыг сумын Хэсгийн төлөөлөгч цагдаагын ахмад (С.Дашдондов), цагдаагийн дэд ахлагч (Р.Содном), Экологийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч (Д.Азбаяр) нарт даалгасугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжийн заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан малчид, иргэдийг холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллахыг засаг даргын орлогч (Д.Гансүх)-д үүрэг болгосугай.

10.Сумын Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/50 дугаар (Мэргэн 4 дүгээр багийн нутаг “Ар гуугын худаг” нэртэй газарт үхэрт боом өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан хязгаарлалтын дэглэм тогтоох тухай) дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



Засаг даргын ^{02.05} оны ⁰⁵ дугаар сарын ⁰⁸ -ны
өдрийн ^{1/36} дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛЫН ХАЛДВАРТ БООМ ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ҮЕД
МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ё.Дамдинпүрэв (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Ж.Ёндонпил (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Ж.Жамъяндагва (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

Д.Отгонцэцэг (Санхүүгийн албаны дарга)

С.Отгонжаргал (Эрүүл мэндийн төвийн дарга)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

С.Дашдондов (Сумын хэсгийн төлөөлөгч цагдаагын ахмад)

Р.Содном (Цагдаагийн дэд ахлагч)

Б.Энхмөнх (Тамгын газрын жолооч)

_____ оОо _____

Засаг даргын ~~2025~~ оны ~~05~~ дугаар сарын ~~30~~-ны
 өдрийн ~~30~~ дугаар захирамжийн хоёрдугаар
 хавсралт

МАЛЫН ХАЛДВАРТ БООМ ӨВЧНИЙ ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН ҮЕД
 ПОСТОНД АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

2025 оны 05 дугаар сарын 22

Хөхбүрд

№	Ээлжийн постын нэр	Овог нэр	Байгууллагын нэр	Хөхбүрд утас
2025.05.22 өдрийн 10 ⁰⁰ цагаас- 2025. 05.27-ны өдрийн 10 ⁰⁰ цаг хүртэл				
1	Бөмбөгөр хайрханы ар	Д.Авид	Засаг даргын Тамгын газрын Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга	89518808
2		А.Буян-Эрдэнэ	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн даатгалын байцаагч	80038803
3		Э.Пүрэвсүрэн	Ерөнхий боловсролын сургуулийн байрны тогооч	86848011
2025.05.22 өдрийн 10 ⁰⁰ цагаас – 2025. 05.27-ны өдрийн 10 ⁰⁰ цаг хүртэл				
1	Хөх хад	Т.Төрбат	Засаг даргын Тамгын газрын Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга	99443010
2		Н.Ганчимэг	Соёлын төвийн үйлчлэгч	99513337
3		Ж.Дөлгөөн	Ерөнхий боловсролын сургуулийн байрны жижүүр	89277707
2025.05.22 өдрийн 10 ⁰⁰ - цагаас – 2025. 05.27-ны өдрийн 10 ⁰⁰ цаг хүртэл				
1	Зээгийн шил	М.Сэр-Од	Засаг даргын Тамгын газрын Асгамба 3 дугаар багийн Засаг дарга	88353537
2		Э.Цэрэням	Соёлын төвийн бүжгийн багш	80492838
3		Н.Гантөгс	Ерөнхий боловсролын сургуулийн байрны жижүүр	96134931
2025.05.27-ны өдрөөс 10 ⁰⁰ цагаас – 2025. 05.31-ний өдрийн 10 ⁰⁰ цаг хүртэл				
1	Хөх хад	Д.Лхагважав	Цэцэрлэгийн харуулч	99584333
2		Сарангэрэл	Цэцэрлэгийн туслах багш	89519441
3		Б.Болортуяа	Соёлын төвийн номын санч, бичиг хэргийн ажилтан	99493336
4	Бөмбөгөр хайрханы ар	Э.Мөнх-Эрдэнэ	Сан хариуцсан нягтлан бодогч	88954359
5		Ё.Лхагвасүрэн	ИТХ-ын мэргэжилтэн	80707029
6		Д.Болормаа	Цэцэрлэгийн туслах багш	88442142
7	Зээгийн шил	П.Сүхдалай	Соёлын төвийн өвийн ажилтан	88464846
8		О.Мөнхцэцэг	Цэцэрлэгийн туслах багш	89904543
9		Ж.Жамъяндагва	Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч	86848288
10		Р.Сувдаа	Эрүүл мэндийн төвийн үйлчлэгч	88448981
2025.05.31-ний өдрөөс 10 ⁰⁰ цагаас – 2025. 06.04-ний өдрийн 18 ⁰⁰ цаг хүртэл				
11	Зээгийн шил	П.Ганбаатар	Ерөнхий боловсролын сургуулийн сантехник	98370619
12		Б.Пүрэвдорж	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан	86026005

1	2	3	4	5
13	Зээгийн шил	Н.Мөнх-Эрдэнэ	Эрүүл мэндийн төвийн багийн эмч	80090997
14		Ж.Ёндонпил	Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч	88300291
15	Бөмбөгөр хайрханы ар	А.Баасанбат	Ерөнхий боловсролын сургуулийн Хоол зүйч	88442799
16		С.Анужин	Ерөнхий боловсролын сургуулийн тогооч	88764913
17		Ш.Алтанцэцэг	Цэцэрлэгийн туслах багш	88202621
18	Хөх хад	З.Ёндонжамц	Улсын бүртгэгч	95642585
19		Ө.Ариунзаяа	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	88722202
20		н.Нарантуяа	Цэцэрлэгийн үйлчлэгч	85119660

_____оОо_____